



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 4/ААХ

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	С.Нацагдорж	Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга
Нарийн бичгийн дарга:	С.Наранбаатар	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Уянга	Нисэх буудлуудын удирдах газрын Нисэх буудлуудын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Гантулга	Газрын тусгай үйлчилгээний албаны Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Б.Энх-Амгалан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /С.Нацагдорж/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /С.Наранбаатар/-д үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН